

UCS 1406B:2022

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ




Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байршуулах
хогийн саванд тавих шаардлага

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байршуулах
хогийн саванд тавих шаардлага

*Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 23-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	5
2. Норматив эшлэл.....	5
3. Нэр томъёоны тодорхойлолт.....	5
4. Хогийн саванд тавих шаардлага	5
5. Төрөл ангилал	6
6. Хогийн савыг байрлуулах	7
7. Хогийн савыг суурилуулах.....	7
8. Хогийн савны материалын шаардлага	8
9. Хогийн савны өнгө.....	9
10. Хог хаягдлыг ангилан ялгах тэмдэг.....	9
11. Засвар үйлчилгээний хяналт.....	10
Гудамж, талбайд байршуулсан хогийн савыг хүлээн авах шалгуур үзүүлэлт	11
Ашигласан материалын жагсаалт	12

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Гудамж зам талбайн хогийн сав жишээ загвар	6
Зураг 2. Дан хогийн сав	6
Зураг 3. Хосолсон хогийн сав	6
Зураг 4. Олон төрлөөр ангилах хогийн сав.....	7
Зураг 5. Тамхи татах цэгийн хогийн сав	7
Зураг 6. Хогийн сав суурилуулах.....	7
Зураг 7. Хэсэглэл-1	8
Зураг 8. Хогийн савны өнгө	9

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хогийн савны хэмжээ.....	6
Хүснэгт 2. Материалын төрөл, үзүүлэлт (Жишээ зураг)	8
Хүснэгт 3. Дахивар хог ангилан ялгах тэмдэг (Жишээ зураг).....	9
Хүснэгт 4. Хогийн савны ашиглалтын байдалд хяналт үнэлгээ хийх чиглэл	10
Хүснэгт 5. Хогийн савыг хүлээн авах шалгуур үзүүлэлт	11



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Г Нийтийн эзэмшлийн эд хөрөнгөд Г
хамаарах хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10^{1.1} дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS1402B:2022 “Нийтийн эзэмшлийн талбайд байгуулах усан оргилуурт тавих ерөнхий шаардлага” хотын стандартыг

1.2. UCS1401B:2022 “Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага” хотын стандарт

1.3. UCS1403B:2022 “Гадна мэдээллийн байгууламжид тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.4. UCS 1404B:2022 “Саравч, сүүдрэвчинд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.5. UCS1405B:2022 “Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага” хотын стандарт

1.6. UCS1406B:2022 “Нийтийн эзэмшлийн зам талбайн хогийн саванд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.7. UCS1407B:2022 “Нийтийн эзэмшлийн зам талбайн сандалд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.8. UCS1408B:2022 “Хөшөө дурсгал, хүндэтгэлийн самбарт тавих ерөнхий шаардлага” хотын стандарт


1.9. UCS1409B:2022 “Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.10. UCS1410B:2022 “Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1110100320

2.Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА  Ж БАТБАЯСГАЛАН



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 25
дугаар тогтоолын зургаадугаар хавсралт

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

UCS 1406B:2022 “НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ, ТАЛБАЙД БАЙРШУУЛАХ ХОГИЙН САВАНД ТАВИХ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг нийтийн эзэмшлийн гудамж, талбайд хогийн сав байршуулахад дагаж мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах хууль, барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- БНБД 3.01.06-90 Барилгын орчны тохижилт;
- БД 32-101-17 Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт;
- БНБД 30.01.04 Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм;
- MNS 6808:2019 Явган хүний зам талбайн төлөвлөлт. Техникийн шаардлага.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Хогийн сав - гэж хог хаягдлыг түр байршуулах, хадгалах сав;

Дахивар - гэж дахин боловсруулах хог хаягдал буюу шил, лааз, хуванцар, төмөр гэх мэт хоёрдогч түүхий эд;

Хогийн савны тэмдэг - гэж хогийн савны зориулалт, дахиврын төрөл, ангиллыг дүрс, өнгөөр ялгасан тэмдэг.

4. ХОГИЙН САВАНД ТАВИХ ШААРДЛАГА

4.1 Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байрлуулсан хогийн сав нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 4.1.1. төлөвлөлтийн дагуу байрлуулсан, олон нийтийн орон зай, амралт чөлөөт цаг өнгөрүүлэх газар, үйлчилгээний төвүүдтэй уялдсан байх;
- 4.1.2. бат бөх, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, зэврэлтээс хамгаалагдсан байх;
- 4.1.3. хогийн савны хог цуглуулах хэсгүүд нь цаасан, дахивар болон бусад хог хаях зориулалтыг заасан стандарт мэдээлэх тэмдэгтэй байх;

- 4.1.4. хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн байх;
 - 4.1.5. хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн тагтай байх;
 - 4.1.6. түгээмэл хэрэглэгддэг угаалга цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бодист тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар материалаар хийх;
 - 4.1.7. хогийн савны металл хийцийн эд ангийг зэврэлтээс хамгаалж стандарт шаардлага хангасан будаг, өнгөөр, технологийн дагуу будах.
- 4.2. Нийтийн эзэмшлийн хогийн савны стандарт хэмжээг Зураг 1 болон Хүснэгт 2-т тус тус үзүүлэв.



Зураг 1. Гудамж, талбайн хогийн сав жишээ загвар

Хүснэгт 1. Хогийн савны хэмжээ

Таних тэмдэг	Хэмжээний нэр	Хэмжээ /мм/
H	Өндөр	900-1100
B	Өргөн	500 (±50)
L	Урт	500 (±50)

5. ТӨРӨЛ АНГИЛАЛ

- 5.1 Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байрлуулах хогийн савыг дан савтай, хос савтай, гурван савтай болон тамхи татах цэгт зориулсан гэж ангилна.



Зураг 2. Дан хогийн сав
(Жишээ зураг)



Зураг 3. Хосолсон хогийн сав
(Жишээ зураг)



Зураг 4. Олон төрлөөр ангилах хогийн сав
(Жишээ зураг)




Зураг 5. Тамхи татах цэгийн хогийн сав
(Жишээ зураг)

6. ХОГИЙН САВЫГ БАЙРЛУУЛАХ


- 6.1 Хогийн сав нь харагдахуйц, хүртээмжтэй байх бөгөөд хөдөлгөөний эрчим төвлөрсөн газруудад байрлуулна.
- 6.2 Хогийн савыг сандлаас 3-аас 14 метр зайд байрлуулна. Мөн орох хаалга, гарц, бие засах газар, явган хүний зам, цэцэрлэгт хүрээлэн, авто зогсоол болон бусад ачаалал ихтэй газрын ойролцоо байрлуулна.

7. ХОГИЙН САВЫГ СУУРИЛУУЛАХ

- 7.1 Хогийн савыг газарт хөдөлгөөнгүй бэхэлж суурилуулах бөгөөд тэлэгч боолт ашиглаж гадаргууд бэхэлнэ.
- 7.2 Хогийн савыг суурилуулах суурийн хэсэглэлийг Зураг 6-д үзүүлэв.



Зураг 6. Хогийн сав суурилуулах (Жишээ зураг)



Зураг 7. Хэсэглэл-1 (Жишээ зураг)

8. ХОГИЙН САВНЫ МАТЕРИАЛЫН ШААРДЛАГА

- 8.1 Хогийн сав нь Монгол орны цаг уурын эрс тэрс нөхцөлд тохирсон, галд тэсвэртэй, зэвэрдэггүй ган буюу металл материалтай байна.
- 8.2 Хогийн савны гадаргуугийн бүрэх металл хуйлмал хавтан нь 2мм буюу түүнээс зузаан байна
- 8.3 Үндсэн рам, хийцийн материалын төрлийг хүснэгт 2-д үзүүлэв.

Хүснэгт 2. Материалын төрөл, үзүүлэлт (Жишээ зураг)

№	Материалын нэр	Төрөл, марк	Зузааны хэмжээ	Огтлолын хэмжээ, мм	Ханын зузааны хэмжээ, мм	Хүндийн хэмжээ, м/кг
1	Дөрвөлжин металл хийц (квадрат)	 (Жишээ зураг)		A=20x20 A=25x25 A=30x30 A=40x40	S=1.5-2.0	1.07-1.39
2	Тэгш өнцөгт металл хийц	 (Жишээ зураг)		A=40x25 A=30x20	S=1.5-2.5	0.64-1.5
3	Металл хавтан	 (Жишээ зураг)		-	S=2-4	0.8-2

9. ХОГИЙН САВНЫ ӨНГӨ

№	Нэр, тэмдэглэгээ	Өнгө	Өнгөний код
1	Ногоон RAL 6016 /#00694c/		C - 84, M - 11, Y - 98, K - 1
2	Саарал RAL 7035 /#c5c7c4/		C - 0, M - 0, Y - 0, K - 30
















Зураг 8. Хогийн савны өнгө

10. ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАН ЯЛГАХ ТЭМДЭГ

10.1. Хог хаягдлыг ангилан ялгах таних тэмдгийг зөв ашиглах нь аливаа хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах үйл ажиллагаанд чухал үүрэгтэй.

10.2. Зааварчилгааны тэмдгийг үндсэн болон нэмэлт тэмдэг гэж ангилна. Дараах хүснэгтэд /Хүснэгт 3./ дахивар хог ялгах таних тэмдгийн хэмжээг үзүүлэв.

Хүснэгт 3. Дахивар хог ангилан ялгах тэмдэг (Жишээ зураг)

Үндсэн тэмдэг 340мм х 240мм	Туслах тэмдэг /Том/ 570мм х 200мм	Туслах тэмдэг /Жижиг/ 370мм х 120мм
		 C86 M21 Y81 K6
		 C0 M60 Y100 K0
		 C88 M52 Y0 K0
		 C75 M68 Y67 K90
		 C20 M100 Y100 K12



Тайлбар: Энэхүү баримт бичигт дурдсан тэмдгийн төрлүүд нь олон улсын жишигт нийцсэн, олон удаагийн туршилт судалгаагаар батлагдсан болно.

11. ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

11.1. Хогийн савны бохирдол, элэгдэл, эвдрэлд тогтсон хуваарийн дагуу хяналт, үнэлгээ засвар, үйлчилгээ хийнэ. Хуваарийг хогийн савны цэвэрлэгээ, үйлчилгээ хариуцсан байгууллагын удирдлага батална.

Хүснэгт 4. Хогийн савны ашиглалтын байдалд хяналт үнэлгээ хийх чиглэл

№	Хяналт үнэлгээ хийх чиглэл	Тийм	Үгүй
1	Цэвэр үзэмжтэй байдал хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Хогийн савны гадаргын бүрэн бүтэн байдал хангагдсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Бэхэлгээ, эд анги, элэгдсэн, суларсан, гэмтсэн, мултарсан, гээгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Зэврэлт үүссэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Эвдэн сүйтгэх үйл ажиллагаанд өртсөн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

ГУДАМЖ, ТАЛБАЙД БАЙРШУУЛСАН ХОГИЙН САВЫГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Гудамж, талбайд байршуулсан хогийн савыг энэхүү стандартад заасан материал, хэмжээ, загвар, байрлуулах, суурилуулах шаардлагыг хангаж байгаа эсэхийг (Хүснэгт 5.)-д заасан загвар үзүүлэлтийн дагуу хянан шалгаж хүлээн авна.

Хүснэгт 5. Хогийн савыг хүлээн авах шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Байрлал - Хогийн савыг харагдахуйц зөв байрлалд, зөв харуулж байршуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Суурилуулалт - Хогийн савыг стандартын дагуу суурилуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Хогийн саванд дахивар, хог хаягдлын тэмдгийг стандартын дагуу байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Хогийн савны багтаамж хүрэлцээтэй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Хогийн сав хэмжээний стандартад нийцэж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Хогийн сав стандартад нийцсэн материалаар хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Хогийн савны металл хийц хэсгүүд зэвэрдэггүй материалаар хийгдсэн аль эсхүл зэврэлтээс хамгаалах будаг түрхлэг стандартын дагуу хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Хогийн сав нь дахивар, цаас, шил, хуванцар, төмөр болон бусад хогийг ялган хаях шаардлагыг хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9	Тамхи татах цэгт зориулсан дахивар хогийн савны стандарт шаардлагыг хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
10	Тамхи татах цэгт зориулалтын хогийн савыг байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
11	Тухайн хэсэгт ашиглагдаж байгаа дахивар хогийн савны нэгэн төрөл, жигд байдал хангагдсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Хотын нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн хогийн сав нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Барилгын орчны тохижилт, БНБД 3.01.06-90
- Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт, БД 32-101-17
- Явган хүний зам талбайн төлөвлөлт. Техникийн шаардлага, MNS 6808:2019
- Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм, БНБД 30.01.04
- Better Practice Guide for Public Place Recycling, <https://www.epa.nsw.gov.au>
- Public place recycling - Sustainability Victoria, <https://www.sustainability.vic.gov.au>
- Waste Signage Guidelines, <https://www.sustainability.vic.gov.au>



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, хяналтын газар